



ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нийцлийн аудитын тайлан

Орон нутгийн хөгжлийн сангийн 2019 оны хөрөнгийн
зарцуулалт, үр дүн



**ОНХС-гийн хөрөнгийг нийгэм, эдийн засгийн ач холбогдол бүхий
хөрөнгө оруулалтад бус, богино хугацааны хэрэгцээ шаардлага
хангах урсгал шинжтэй зардалд төлөвлөж, зарцуулснаас
ОНХС-гийн зорилт бүрэн хангагдаагүй байна**

Чойр хот
2020 он

АГУУЛГА

Тайланг бэлтгэсэн:	Товчилсон үгийн тайлбар	4
Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газар	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	5
Дарга, тэргүүлэх аудитор Б.Сарантуяа Аудитын менежер Г.Наранбаяр Ахлах аудитор Ц.Батсайхан Аудитор М.Ундармаа	1.1 ОНХНС-ийн эх үүсвэрийг хууль журамд заасны дагуу төлөвлөсөн боловч нийт 10.9 сая төгрөгийн санхүүжилт дутуу олгогдсон байна.	8
	1.1.1 ОНХНС-гийн эх үүсвэрийг батлагдсан аргачлалын дагуу тооцож төлөвлөсөн байна.	8
	1.1.2. ОНХНС-гийн эх үүсвэрийг төсвийн тухай хуулийн дагуу бүрдүүлсэн боловч гүйцэтгэлээр олгосон санхүүжилт 10.9 сая төгрөгөөр дутуу байна.	8
	1.1.3 ОНХНС-гаас аймагт олгох орлогын шилжүүлгийг батлагдсан хуваарийн дагуу олгоогүй байна.	9
	1.2 Аймгийн ОНХС-гийн хөрөнгийн эх үүсвэрийг хууль журамд заасны дагуу төлөвлөсөн боловч ОН-ийн төсвөөс санхүүжих орлогыг 25.0 сая төгрөгөөр дутуу хуваарилсан байна.	9
	1.2.1 Аймаг, сумдын ОНХС-гийн орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх эх үүсвэрийг төлөвлөхдөө өмнөх оны үлдэгдлийг дутуу тооцоолсон байна.	9
	1.2.2 Аймаг, сумдын ОНХС-гийн эх үүсвэрийг 5 нэр, төрлийн орлогоос бүрдүүлсэн байна.....	10
	1.2.3 Аймгийн ОНХС-гаас сумдын ОНХС-д олгох орлогын шилжүүлэг батлагдсан хуваариас дутуу санхүүжигдсэн байна.....	10
2020 оны 10-11 дүгээр сар	2.1 Аймаг, сумдын ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжигдэх хөтөлбөр, төсөл арга хэмжээний төлөвлөлтөд иргэдийн идэвхи оролцоо хангалтгүй байна.	12
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 7054-3156 дугаарын утас,7054-3179 дугаарын факсаар харилцана уу.	2.1.1 Шивээговь сумын ИТХ нь зураг төсөвгүй 50.0 сая төгрөгийн 1 төсөл, арга хэмжээг ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр баталсан байна.	12
	2.1.2 ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлтөд иргэдийн мэдээлэл дутмаг, оролцоо, идэвх хангалтгүй байна.....	13
Байгууллагын хаяг:	2.2. ОНХС-гийн хөрөнгийг нийгэм, эдийн засгийн ач холбогдол багатай, богино хугацааны хэрэгцээ шаардлага хангасан төсөл, хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсаар байна.	14
ГСА Сүмбэр сум 3-р баг, Нутгийн удирдлагын ордон 2-р давхар 6 корпус 208 тоот	2.2.1 ОНХС-гийн хөрөнгөөр сум, орон нутагт бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулсан байна.....	14
	2.2.2 Аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр хийгдсэн хөрөнгө оруулалтын зарим ажилд захиалагчийн хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүйгээс дутуу хийгдсэн ажлыг улсын комисс хүлээн авсан байна.	16
	2.2.3 ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтыг холбогдох байгууллагын данс бүртгэлд	

	бүртгүүлэх шийдвэр гарсан боловч ашиглагч байгууллагад бүрэн бүртгэгдээгүй байна.....	20
	3.1. ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлд хяналт шинжилгээ үнэлгээ хийгээгүй байна.	20
	3.1.1 Баянтал сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөтөлбөр, төсөл арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлийн явцад хяналт тавьж ажиллаагүй байна.....	20
	3.1.2 Аймаг, сумын захиргааны байгууллага ОНХС-гийн хэрэгжилт, үр дүнд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийгээгүй байна.....	21
	3.2 ОНХС-гийн тайлан, үр дүнг АИТХ-аар хэлэлцээгүй байна.	22
	3.2.1 ОНХС-гийн тайланг холбогдох байгуулагад хүргүүлж ажилласан боловч үр дүнг хэлэлцээгүй байна.....	22
	3.2.2 Өмнөх аудитаар өгөгдсөн албан шаардлагыг хэрэгжүүлж, зөвлөмжөөр өгөгдсөн зөрчлийг давтан гаргасан байна.	23
	3.2.3 Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн төлөвлөлтийг бодитой хийгээгүйгээс тус сангийн үйл ажиллагаа нь орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоо бүрэн хангаагүй байна.	23
	ДҮГНЭЛТ	24
	ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛДҮГНЭЛТ	24
	АУДИТЫН ЗӨВЛӨМЖ	24
	ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ	24
	ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛД ХИЙСЭН ТАЙЛБАР	24

Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АЗДТГ	Аймгийн Засаг даргын тамгын газар
АИТХ	Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурал
АМ	Ашигт малтмал
АМНАТ	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр
АМХБАТЗ	Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл
АОНХС	Аймгийн Орон нутгийн хөгжлийн сан
ГХБХБГ	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар
ИНХ	Иргэдийн нийтийн хурал
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ИТХТ	Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчид
НАТ	Нөөц ашигласны төлбөр
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
НТШ	Нээлттэй тендер шалгаруулалт
ОН	Орон нутаг
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СТСХ	Санхүү төрийн сангийн хэлтэс
ТА-3	Тогтвортой амьжиргаа -3 төсөл
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдаа авах тухай
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХОХБТХ	Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ШХА	Шууд худалдан авалт

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

1. Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2019 оны “Аудитын сэдэв батлах тухай” 05 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторовн 2020 оны А/53 дугаар тушаал, Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэв.

2. Аудитын зорилго, зорилт

Орон нутгийн хөгжлийн сангийн 2019 оны хөрөнгийн зарцуулалт хууль тогтоомжид нийцсэн эсэхэд аудит хийж, дүгнэлт, зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх, аудитын тайланг ЯАГ аймаг, сумдын Засаг дарга нарт болон холбогдох бусад байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ.

3. Аудитын хамрах хүрээ

Аудитад аймаг, сумдын ИТХ, Засаг дарга, ИНХ, багийн Засаг дарга, ХОХБТХ, СТСХ болон холбогдох албан тушаалтнуудыг хамруулж, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн 2019 оны орлого бүрдүүлэлт, төсөв төлөвлөгөө, хуваарилалт болон хэрэгжүүлсэн хөтөлбөр, төсөл арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, санхүүжилт, хяналт, тайлагнал зэргийг авч үзлээ.

4. Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитыг гүйцэтгэхдээ АДБОУС 100-400, 4000 дугаар стандартууд, МУЕА-ын 2016 оны А/146 дугаар тушаалаар батлагдсан “Нийцлийн аудитын түр журам”-ыг баримтлан аудитын арга зүйн дагуу орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагаанд мөрдөгдөж буй хууль, тогтоол, түүнийг дагалдан гаргасан эрх зүйн актуудын хүрээнд хэрэгжүүлэгч байгууллага, нэгжийн холбогдох албан тушаалтантай ярилцлага хийх, санал асуулга, лавлагаа, тодруулга авч бусад шаардлагатай баримт материалд тулгуурлан дүн шинжилгээ хийх, үйл ажиллагааны хүрээнд хэрэгжүүлсэн зорилтод арга хэмжээнээс түүвэрлэн горим сорил хэрэгжүүллээ.

Мөн аудитын хүрээнд ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлийн талаарх иргэдийн мэдээлэл, оролцоог үнэлэх зорилгоор аймаг болон 3 сумын нийт 163 иргэнээс санал асуулга авлаа.

Аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ, судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

5. Аудитын багийн бүрэлдэхүүн

Аудитыг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Б.Сарантуяа хянан удирдаж, аудитын менежер Г.Наранбаяр үе шатны хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Ц.Батсайхан, аудитор М.Ундармаа нар хийж гүйцэтгэлээ.

6. Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгагдсан мэдээлэл

Аудитын тайлан нь оршил хэсэг, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж, холбогдох байгууллагын санал, түүнд өгсөн тайлбар, хавсралт гэсэн бүтцээр үндсэн зорилтын дагуу бичигдсэн.

7. Үндсэн мэдээлэл

ОНХНС болон улсын төсвөөс аймаг, нийслэлийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг тооцохдоо Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлэг тооцох аргачлал”, Сангийн сайдын 2016 оны 17 дугаар тушаалаар батлагдсан “Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн орлогоос орон нутгийн хөгжлийн санд олгох шилжүүлэг тооцох аргачлал”-ыг тус тус мөрдөж байна.

Мөн орон нутгийн удирдлага улсын төсвөөс орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор хуваарилагдсан хөрөнгийг төлөвлөх, батлах, хуваарилах, нутгийн захиргаа, иргэд, олон нийтийн оролцоотой хамтын шийдвэрээр ил тод хариуцлагатай захиран зарцуулах, хяналт тавих, тайлагнах үйл ажиллагааг Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар батлагдсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”, 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”, 2018 оны 288 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ыг тус тус баримтлан хэрэгжүүлж байна.

Монгол Улсын 2019 оны Төсвийн тухай хуулиар Говьсүмбэр аймагт ОНХНС болон улсын төсвөөс ОНХС-д олгох орлогын шилжүүлгийн хэмжээг 926.3 сая төгрөгөөр баталсан бөгөөд тайлант онд уг хуульд нэмэлт өөрчлөлт ороогүй байна.

2019 онд аймгийн хэмжээнд ОНХС-д нийт 1,912.7 сая төгрөгийн эх үүсвэр бүрдүүлж ажилласан байна. Үүнд: Өмнөх оны үлдэгдлээс 670.0 сая, ОНХНС-гаас 762.5 сая, Тогтвортой амьжиргаа-3 төслөөс 152.9 сая, орон нутгийн төсвийн орлогоос 327.3 сая төгрөгийг тус тус бүрдүүлсэн байна.

Аймаг, сумдын ОНХС-гийн эх үүсвэрийг хүснэгтээр харуулбал:

/сая төгрөгөөр/

Сангийн нэр	Өмнөх оны үлдэгдлээс	ОНХНС-гаас	Тогтвортой амьжиргаа-3 төслөөс	Орон нутгийн төсвийн орлогоос	Нийт
Аймгийн ОНХС	617.2	546.4	-	110.0	1,273.6
Сүмбэр ОНХС	8.9	155.3	21.3	210.2	395.7
Шивээговь ОНХС	21.7	53.7	75.8	7.2	158.4
Баянтал ОНХС	22.2	7.0	55.8		85.0
Нийт дүн	670.0	762.5	152.9	327.3	1,912.7

Хүснэгтээс харахад: Нийт эх үүсвэрийн 67% буюу 1,273.6 сая төгрөгийг АОНХС, 21% буюу 395.7 сая төгрөгийг Сүмбэр сумын ОНХС, 8 % буюу 158.4 сая төгрөгийг Шивээговь сумын ОНХС, 4% буюу 85.0 сая төгрөгийг Баянтал сумын ОНХС тус тус эзэлж байна.

2019 онд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 83 хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээнд нийт 1,948.6 сая төгрөгийн төсөв батлагдсан ба зөвхөн аймгийн ОНХС-д 2018 оны шилжих үлдэгдлээс санхүүжүүлэх зардлын жагсаалтыг 3 арга хэмжээнд 55.0 сая төгрөгөөр нэмж баталсан байна.

Аймаг сумдын ОНХС-д нийт 1,912.7 сая төгрөгийн санхүүжилтээс гүйцэтгэлээр 1,720.3 сая төгрөгийг төсөл арга хэмжээнд зарцуулж, 235.7 сая төгрөгийн мөнгөн үлдэгдэлтэй тайлагнасан байна.

Бүлэг 1

ОНХС-гийн хөрөнгийг хууль журамд заасны дагуу 926.3 сая төгрөгөөр төлөвлөсөн боловч ОНХС-аас нийт 10.9 сая төгрөгийн санхүүжилтийг дутуу авсан байна.

1.1 ОНХС-гийн эх үүсвэрийг хууль журамд заасны дагуу төлөвлөсөн боловч нийт 10.9 сая төгрөгийн санхүүжилт дутуу олгогдсон байна.

1.1.1 ОНХС-гийн эх үүсвэрийг батлагдсан аргачлалын дагуу тооцож төлөвлөсөн байна.

ОНХС-гаас Говьсүмбэр аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийн төлөвлөлтийг Төсвийн тухай хууль болон Засгийн газрын 2017 оны 230 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон Орон нутгийн хөгжлийн сангаас олгох орлогын шилжүүлгийг тооцох аргачлал”-ын дагуу орон нутгийн хөгжлийн индекс, хүн амын тоо, нутаг дэвсгэрийн хэмжээ, аймгийн төвөөс нийслэл хот хүртэлх хот хоорондын замын урт, орон нутгийн татварын идэвх санаачилга зэрэг шалгуур үзүүлэлтийг тус тус үндэслэн тооцоолсон байна.

2019 онд Говьсүмбэр аймагт хуваарилах эх үүсвэрийн төлөвлөлтийг дүрслэлээр харуулбал:

Дүрслэл №1

Дүрслэлээс харахад: дотоодын НӨАТ-аас 251.9 сая, газрын тосны НАТ-аас 98.7 сая, АМНАТ-аас 407,4 сая, АМ-ын хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөрөөс 15.4 сая, Тогтвортой амьжиргаа-3 төслөөс 152.9 сая, нийт 926.3 сая төгрөгийг төлөвлөсөн байна. Үүнээс суурь зарлагад 60.3 сая, Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй суманд 15.3 сая төгрөгийг, Тогтвортой амьжиргаа-3 төслийн 152.9 сая төгрөгийг эх үүсвэрийг сумдад, 697.7 сая төгрөгийн 30% ийг сумдад 70%-ийг аймгийн ОНХС-д тус тус хуваарилсан байна.



1.1.2. ОНХС-гийн эх үүсвэрийг төсвийн тухай хуулийн дагуу бүрдүүлсэн боловч гүйцэтгэлээр олгосон санхүүжилт 10.9 сая төгрөгөөр дутуу байна.

2019 оны орлогын шилжүүлгийн гүйцэтгэлийг харуулбал /сая.төг/:

Хүснэгт №1

Эх үүсвэр /сая. төг/	Дотоодын н НӨАТ	Газрын тосны НАТ	АМНАТ	АМ-ын хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр	ТА-3 төслийн урамшуул ал	ТА-3 төслийн н дэмжлэг	Нийт эх үүсвэр
Төлөвлөгөө	251.9	98.7	407.4	15.4	61.4	91.5	926.3
Гүйцэтгэл	266.7	63.3	428.0	4.5	61.4	91.5	915.3
Зөрүү	-14.8	35.4	-20.6	10.9	0.0	0.0	10.9

Хүснэгтээс харахад: ОНХНС-гийн эх үүсвэрийг Төсвийн тухай хуульд заасны дагуу орлогын 6 нэр төрлөөр бүрдүүлсэн байна. Гүйцэтгэлээр аймагт ОНХНС-гаас 10.9 сая төгрөгийн дутуу санхүүжилт олгосон байна.

1.1.3 ОНХНС-гаас аймагт олгох орлогын шилжүүлгийг батлагдсан хуваарийн дагуу олгоогүй байна.

ОНХНС-гаас олгох шилжүүлгийн батлагдсан хуваарь гүйцэтгэлээр харуулбал /сая.төг/:

Улирал	Батлагдсан хуваарь	Гүйцэтгэл	Хүснэгт №2 Зөрүү
I	105.7	102.4	3.3
II	330.3	328.0	2.3
III	263.1	202.9	60.2
IV	227.1	282.0	(54.9)
Нийт дүн	926.3	915.3	10.9

Хүснэгтээс харахад ОНХНС-гаас олгох орлогын шилжүүлгийг батлагдсан хуваарийн дагуу бүрэн олгоогүй бөгөөд 10.9 сая төгрөг дутуу олгосон байна. Тухайлбал: ОНХНС-гаас 2019 оны санхүүжилтийг 1, 2, 3 дугаар улиралд 2.3-60.2 төгрөгөөр дутуу олгож ирсэн бөгөөд 4 дүгээр улиралд нөхөн олгосон боловч нийт дүнгээрээ 10.9 сая төгрөгөөр дутуу санхүүжигдсэн байна.

1.2 Аймгийн ОНХС-гийн хөрөнгийн эх үүсвэрийг хууль журамд заасны дагуу төлөвлөсөн боловч ОН-ийн төсвөөс санхүүжих орлогыг 25.0 сая төгрөгөөр дутуу хуваарилсан байна.

1.2.1 Аймаг, сумдын ОНХС-гийн орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх эх үүсвэрийг төлөвлөхдөө өмнөх оны үлдэгдлийг дутуу тооцоолсон байна.

ОНХС-гийн эх үүсвэрийг Төсвийн тухай хуульд заасны дагуу ОНХНС-гаас 926.2 сая, өмнөх оны үлдэгдлээс 670.0 сая, татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх болон зарлагыг хэмнэх замаар бий болгосон нэмэгдэл эх үүсвэрээс 352.4 сая, нийт 1,948.6 сая төгрөгөөр төлөвлөсөн байна.

Орлогын төлөвлөлтийг хүснэгтээр харуулбал /сая.төг/:

ОНХС-гийн нэр	ОНХНС	ОНХС-гийн эхний үлдэгдлээс	ОН-ийн орлогоос	Хүснэгт №3 Нийт дүн
Аймаг	540.4	617.2	135.0	1,292.7
Сүмбэр	1807.9	8.9	210.2	407.0
Шивээговь	132.5	21.7	7.2	161.3
Баянтал	65.4	22.2	-	87.6
Дүн	926.3	670.0	352.3	1,948.6

Хүснэгтээс харахад ОНХС-гийн эх үүсвэрийн 66%-ийг аймгийн ОНХС, 21%-ийг Сүмбэр сумын ОНХС, 8%-ийг Шивээговь сумын ОНХС, 4%-ийг Баянтал сумын ОНХС тус тус эзэлж байна.

Харин төсөвт тодотгол хийгээгүйгээс өмнөх оны эхний үлдэгдлээс санхүүжих орлогыг аймгийн АОНХС-19.4 сая, Сүмбэр сумын ОНХС 23.6 сая, Шивээговь сумын

ОНХС-0.1 сая, нийт 43.1 сая төгрөгийн эхний үлдэгдлийг тус тус дутуу тооцоолж төлөвлөсөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Засгийн газрын 2012 оны 244 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 6.2.1 дэх заалтыг тус тус зөрчсөн байна.

Цаашид аймаг, сумдын Төрийн сангийн холбогдох мэргэжилтнүүдэд ОНХС-гийн эхний үлдэгдлийг үнэн зөв тооцож төлөвлөж байх **зөвлөмж** өгөхөөр шийдвэрлэв.

1.2.2 Аймаг, сумдын ОНХС-гийн эх үүсвэрийг 5 нэр, төрлийн орлогоос бүрдүүлсэн байна.

Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2-т заасны дагуу аймаг, сумдын ОНХС-гийн орлогын эх үүсвэрийн нийт 1,912.7 сая төгрөг нь дараах нэр, төрлийн орлогоос бүрдүүлсэн байна. Үүнд:

1. ОНХНС-гаас олгох шилжүүлгийн орлого - 762.4 сая төгрөг
2. Орон нутгийн татварын орлого - 80.0 сая төгрөг
3. 2018 оны дансны үлдэгдэл - 670.0 сая төгрөг
4. 2018 оны давсан орлого, хэмнэгдсэн зардал - 247.4 сая төгрөг
5. Тогтвортой амьжиргаа-3 төсөл - 152.9 сая төгрөг

Аймаг, сумдын ОНХС-гийн орлогын эх үүсвэрийг хүснэгтээр харуулбал:

ОНХС-гийн орлогын нэр	Аймгийн ОНХС	Сүмбэр сумын ОНХС	Шивээговь сумын ОНХС	Баянтал сумын ОНХС	Хүснэгт №4 /сая.төг/	
					Нийт дүн	
ОНХНС-гаас олгох шилжүүлгийн орлого	546.4	155.3	53.7	7.0	762.4	
ОН-ийн төсвийн орлого	80.0				80.0	
2018 оны дансны үлдэгдэл	617.2	8.9	21.7	22.2	670.0	
2018 оны давсан орлого, хэмнэгдсэн зардлаас	30.0	210.2	7.2		247.4	
Тогтвортой амьжиргаа-3 төсөл		75.8	55.8	21.3	152.9	
Нийт дүн	1,273.6	450.2	138.4	50.5	1,912.7	

Хүснэгтээс харахад: Нийт эх үүсвэрийн 40%-ийг ОНХНС-гийн шилжүүлгийн орлогоос, 4%-ийг ОН-ийн төсвийн орлогоос, 35%-ийг 2018 оны дансны үлдэгдлээс, 13%-ийг 2018 оны давсан орлого, хэмнэгдсэн зардлаас, 8%-ийг “Тогтвортой амьжиргаа-3” төслөөс тус тус бүрдүүлсэн байна.

1.2.3 Аймгийн ОНХС-гаас сумдын ОНХС-д олгох орлогын шилжүүлэг батлагдсан хуваариас дутуу санхүүжигдсэн байна.

Аймгийн ОНХС-ийн орлогын эх үүсвэр нь төлөвлөснөөс ОНХНС-гаас 10.9 сая, аймгийн орон нутгийн орлогоос 25.0 сая, нийт 35.9 сая төгрөгөөр дутуу санхүүжигдсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 41 дүгээр зүйлийн 41.2.1, Засгийн газрын 2012 оны 244 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн төсвийн

төсөл боловсруулах журам”-ын 6 дугаар зүйлийн 6.2.3 дах заалтыг тус тус зөрчсөн байна.

Иймд Орон нутгийн орлогоос ОНХС-д олгох эх үүсвэрийг хуваарийн дагуу санхүүжүүлж байх **зөвлөмж**-ийг аймгийн СТСХ-т өгөхөөр шийдвэрлэв.

Сумдын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг улирлаар харуулбал:

Хүснэгт №5
/сая.төг/

Улир ал	Сүмбэр			Шивээговь			Баянтал		
	Төлөвлө гөө	Гүйцэтг эл	Зөрүү	Төлөвлө гөө	Гүйцэтг эл	Зөрүү	Төлөвл өгөө	Гүйцэ тгэл	Зөрүү
I	14.7	14.7	-	11.2	11.2	0.0	5.5	5.5	0.0
II	108.1	108.1	-	73.4	73.4	-	31.0	31.0	0.0
III	37.8	37.8	-	27.8	27.8	-	14.4	14.4	-
IV	27.3	24.3	3.1	20.1	17.2	2.9	14.4	11.8	2.6
Нийт	187.9	184.9	3.1	132.5	129.5	2.9	65.4	62.8	2.6

Хүснэгтээс харахад: Сумдад нийт 8.6 сая төгрөгийн санхүүжилтийг дутуу олгосон байна. Тухайлбал: Сүмбэр суманд 3.1 сая, Шивээговь суманд 2.9 сая, Баянтал суманд 2.6 сая төгрөгийг тус тус 4 дүгээр улиралд дутуу олгосон бөгөөд энэ нь ОНХНС-гаас аймагт олгох орлогын шилжүүлгийг батлагдсан хуваарийн дагуу олгоогүйгээс сумдын ОНХС-д олгох орлогын шилжүүлэг дутуу санхүүжигдсэн байна.

ОНХНС-гаас Говьсүмбэр аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийн төлөвлөлтийг Төсвийн тухай хууль болон Засгийн газрын 2017 оны 230 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон Орон нутгийн хөгжлийн сангаас олгох орлогын шилжүүлгийг тооцох аргачлал”-ын дагуу орон нутгийн хөгжлийн индекс, хүн амын тоо, нутаг дэвсгэрийн хэмжээ, аймгийн төвөөс нийслэл хот хүртэлх хот хоорондын замын урт, орон нутгийн татварын идэвх санаачилга зэрэг шалгуур үзүүлэлтийг тус тус үндэслэн тооцоолсон байна.

Бүлэг 2

ОНХС-гийн хөрөнгийг нийгэм эдийн засгийн ач холбогдол бүхий урт удаан хугацаанд үр өгөөжөө өгөх хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажилд зарцуулах шаардлагатай байна.

2.1 Аймаг, сумдын ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжигдэх хөтөлбөр, төсөл арга хэмжээний төлөвлөлтөд иргэдийн идэвх оролцоо хангалтгүй байна.

2.1.1 Шивээговь сумын ИТХ нь зураг төсөвгүй 50.0 сая төгрөгийн 1 төсөл, арга хэмжээг ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр баталсан байна.

2019 онд ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжих хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээг төлөвлөхдөө Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 5, 6 дугаар зүйлийг үндэслэн ажлын хэсэг урьдчилсан жагсаалт бэлтгэн иргэдэд танилцуулж санал авсан бөгөөд багийн Засаг дарга нар иргэдээс авсан саналыг нэгтгэн эрэмбэлж багийн ИНХ-аар хэлэлцэж сумдын Засаг дарга нарт хүргүүлсэн байна.

ОНХС-гийн заавар журам аргачлалын талаар Тогтвортой амьжиргаа-3 төслийн Говьүмбэр аймаг дахь мэргэжилтэн сумдад ажиллаж заавар, зөвлөгөө өгч ажилласнаар баримтын бүрдлийг хангасан байдал өмнөх оноос сайжирсан байна.

Сумдын ОНХС-гийн эх үүсвэрээр 2019 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээг тухайн орон нутгийг хөгжүүлэх бодлогын баримт бичиг, Засаг даргын хэрэгжүүлэх үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, эдийн засаг, нийгмийн зорилт зэрэг бодлогын баримт бичгүүдтэй уялдуулан төлөвлөсөн байна.

Харин Шивээговь сумын ИТХ-аар ЗДТГ-ын эрэмбэлэгдсэн жагсаалтад ороогүй, зураг төсөв батлагдаагүй “Төв талбайг тохижуулах, усан оргилуур байгуулах” 50.0 сая төгрөгийн 1 ажлыг баталсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3.6, Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3 дугаар зүйлийн 3.1.3, 3.1.4 дэх заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд Шивээговь сумын Засаг даргад ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө холбогдох хууль тогтоомж, зааврыг баримтлан олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, иргэдийн саналыг үнэн бодитой байдлаар тусгаж, зураг төсөвгүй арга хэмжээг төлөвлөхгүй байх тал дээр анхаарч ажиллах **зөвлөмж** өгөхөөр шийдвэрлэв.

2.1.2 ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлтөд иргэдийн мэдээлэл дутмаг, оролцоо, идэвх хангалтгүй байна.

2019 онд ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжих хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээг төлөвлөхдөө Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 7 дугаар зүйлийг үндэслэн аймгийн ЗД-ын 2018 оны А/201 дугаартай захирамжаар холбогдох хэлтсийн албан тушаалтнууд иргэний нийгмийн байгууллагын төлөөллийг оролцуулан 10 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулсан байна.

Ажлын хэсэг нь сумдын ЗДТГ-аас ирүүлсэн сумын төсөвт хүрэлцэхээргүй санал, төрийн болон төрийн өмчит байгууллагуудаас ирүүлсэн саналыг урьдчилсан жагсаалтад нэмж тусган аймгийн хөгжлийн бодлого, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт нийцүүлэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалтыг гарган иргэдийн дунд нээлттэй хэлэлцүүлгээр 7 дугаар сард хэлэлцэж саналыг эрэмбэлсэн байна.

Эрэмбэлсэн ажлын жагсаалтыг аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэж, нэгдсэн жагсаалтыг орон нутгийн төсөвт тусган аймгийн ИТХ-аар батлуулсан байна.

2019 онд аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээнд нийт 1,237.7 сая төгрөгийн төсөв батлагдаж, аймгийн ИТХ-ын 2019.06.18-ны өдрийн хуралдааны 04 дүгээр тогтоолоор 2019 оны орон нутгийн төсвийн шилжих үлдэгдлээс 30.0 сая төгрөгийг “Биеийн тамирыг дэмжих” аймгийн хөтөлбөр болон “Хөдөлмөрийн зах зээлийн судалгаа, шинжилгээ хийлгэх арга хэмжээний зардалд, 2019 оны ОНХО-ын ажлын жагсаалтын 1.1.1 буюу Боржигон сэцэн вангийн хошууны толь бичиг номын 2-р боть бэлтгэх ажлын 25.0 сая төгрөгийг хасаж, аймгийн баяр наадмын зардалд нэмж, нийт 55.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж, нийт 1,292.7 сая төгрөгөөр баталсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, 16 дугаар зүйлийн 16.5.5, МУЗГ-ын 271 дүгээр тогтоолоор баталсан “Жишиг хэмжээг шинэчлэн тогтоох тухай” журмын 1 дүгээр зүйлийг тус тус зөрчсөн байна.

Цаашид аймгийн ИТХ-д ОНХС-гийн хөтөлбөр арга хэмжээний зардлыг нэмэгдүүлж батлахгүй байх, жишиг хэмжээ тогтоосон тогтоол шийдвэрийг зөрчихгүй байх **зөвлөмж** өгөхөөр шийдвэрлэв.

ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг төлөвлөх, иргэд, олон нийтийн оролцоог хангахдаа саналын хуудсаар нээлттэй байдлаар иргэдээс санал авч, саналыг эрэмбэлэн тухайн шатны ИТХ-д сумдын ЗДТГ нар өргөн мэдүүлсэн талаар баримт материал бүрдүүлсэн боловч иргэдийн мэдээлэл дутмаг, оролцоо, идэвх хангалтгүй байгаа нь аудитын явцад хийгдсэн санал асуулгаас харагдаж байна.

Аудитын явцад хийгдсэн санал, асуулгад нийт 163 иргэнийг хамруулсан ба дараах байдлаар хариулсан байна. Үүнд:

- “Орон нутгийн хөгжлийн сангийн талаар хэр мэдээлэлтэй вэ?” гэсэн санал асуулгад 59 нь буюу 36% нь хангалттай, 104 нь буюу 64% нь хангалтгүй,

- “Та Орон нутгийн хөгжлийн сангийн талаарх мэдээллийг хаанаас авсан бэ?” гэсэн санал асуулгад 23 нь буюу 14% нь Засаг дарга, хороодын хэсгийн ахлагч, 77 нь буюу 47% нь Орон нутгийн мэдээллийн самбар олон нийтийн сүлжээнээс, 2 нь буюу 1% нь иргэний танхимын ажилтнаас, 61 нь буюу 37% нь нутгийн иргэдээс мэдээлэл авсан,
- “Та Орон нутгийн хөгжлийн сангийн талаарх холбогдох хууль тогтоомж, журам зааврыг судалж үзсэн уу?” гэсэн асуулгад 52 буюу 32% нь тийм, 111 буюу 68% нь үгүй,
- “Таны баг, хорооны Засаг дарга 2019 онд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хамгийн түрүүнд хийх шаардлагатай ажлуудын саналыг иргэдээс авах ажлыг зохион байгуулсан уу?” гэсэн асуулгад 70 буюу 43 % нь тийм, 31 буюу 19% нь үгүй, 62 буюу 38% нь сайн мэдэхгүй байна,
- “Та энэ үйл ажиллагаанд оролцож саналаа өгсөн үү?” гэсэн асуулгад 64 буюу 39% нь тийм, 99 буюу 61% нь үгүй,
- “Засаг дарга ийнхүү авсан саналыг эрэмбэлж, хамгийн их санал авсан ажлуудыг иргэдэд танилцуулж, нээлттэй хэлэлцүүлэг хийсэн үү?” гэсэн асуулгад 51 буюу 31 % нь тийм, 35 нь буюу 21% нь үгүй, 77 нь буюу 47% нь сайн мэдэхгүй,
- “Та нээлттэй хэлэлцүүлэгт оролцсон уу?” гэсэн асуулгад 46 буюу 28 нь тийм, 117 буюу 72 нь үгүй гэж тус тус хариулжээ.

Санал, асуулгаас харахад ОНХС-гийн зорилтыг бүрэн хэрэгжүүлэхийн тулд иргэдэд мэдээллийг үр дүнтэй, ойлгомжтой байдлаар хүргэх, иргэдийн оролцоог нэмэгдүүлж, хяналтыг бий болгож ажлыг эрчимжүүлэх шаардлагатайг харуулж байна.

2.2. ОНХС-гийн хөрөнгийг нийгэм, эдийн засгийн ач холбогдол багатай, богино хугацааны хэрэгцээ шаардлага хангасан төсөл, хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсаар байна.

2.2.1 ОНХС-гийн хөрөнгөөр сум, орон нутагт бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулсан байна.

2019 онд шинээр хэрэгжүүлэх ажлын жагсаалтад хөрөнгө оруулалтын шинжтэй 356.6 сая төгрөгийн 15 ажил, тоног төхөөрөмж худалдан авах 118.3 сая төгрөгийн 9 ажил, их засварын 235.7 сая төгрөгийн 4 ажил, нийт 710.6 сая төгрөгийн 28 ажил батлагдсан байна.

2019 онд ОНХС-гийн хөрөнгөөр худалдан авах ажил, үйлчилгээний жагсаалтыг харуулбал /сая.төг/:

Хүснэгт №6

ОНХС-гийн нэр	Шинээр эхлэх хөрөнгө оруулалт		Тоног төхөөрөмж		Их засвар		Хөтөлбөр төсөл, арга хэмжээ		Нийт дүн	
	Тоо	Төсөвт өртөг	Тоо	Төсөвт өртөг	Тоо	Төсөвт өртөг	Тоо	Төсөвт өртөг	Тоо	Төсөвт өртөг
АОНХС	4	168.7	1	24.0	1	41.7	23	506.3	29	740.6
Сүмбэр сумын ОНХС	3	49.2	2	46.6	3	194.0	8	108.3	16	398.1

Шивээговь сумын ОНХС	4	113.5	3	20.0			5	27.8	12	161.3
Баянтал сумын ОНХС	4	25.2	3	27.7			4	21.0	11	73.9
Нийт дүн	15	356.6	9	118.3	4	235.7	40	663.4	69	1,374.0

Хүснэгтээс харахад нийт батлагдсан төсвийн 26%-ийг шинээр эхлэх хөрөнгө оруулалт, 9%-ийг, тоног төхөөрөмж, 17%-ийг их засвар, 48%-ийг хөтөлбөр, төсөл арга хэмжээ тус тус эзэлж байна.

Аймгийн хэмжээнд 2019 онд төлөвлөсөн нийт ажлын 48%-ийг хөтөлбөр, төсөл арга хэмжээ эзэлж байгаа бөгөөд нэг удаагийн урсгал зардлын шинжтэй уралдаан тэмцээн, сургалт, буцалтгүй тусламж, дэмжлэг зэрэгт зарцуулахаар төлөвлөж баталсан нь сангийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах нөхцөл бүрдүүлсэн байна.

Худалдан авах ажиллагааны төлөвлөлтөд ТБОНӨХБАҮХАТХ болон 2013 оны Засгийн газрын “Босго үнэ батлах тухай” 68 дугаар тушаалын дагуу ОНХС-гаар хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын ажлаас аймгийн ОНХС-д 218.1 сая төгрөгийн 4 ажил, Сүмбэр сумын ОНХС-д 270.8 сая төгрөгийн 6 ажил, Шивээговь сумын ОНХС-д 105.5 сая төгрөгийн 3 ажил, Баянтал сумын ОНХС-д 12.5 сая төгрөгийн 1 ажил, нийт 606.9 сая төгрөгийн 14 ажилд тендер шалгаруулалт зарласан байна.

Аймаг, сумдын ОНХС-гийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг хүснэгтээр харуулбал /сая.төг/:

ОНХС-гийн нэр	Тоо	Төсөв өртөг	Хүснэгт №7 Худалдан авах ажиллагаанд мөрдөх журам					
			Тоо	НТШ	Тоо	ХА	Тоо	ЗҮ
Аймгийн ОНХС	4	218.1	2	154.1	1	24.0	1	40.0
Сүмбэр сумын ОНХС	6	270.8	1	90.0	5	170.8	1	10.0
Шивээговь сумын ОНХС	3	105.5			2	65.0	1	40.5
Баянтал сумын ОНХС	1	12.5			1	12.5		
Аймгийн нийт дүн	14	606.9	3	244.1	9	272.3	3	90.5

Аймаг, сумдын ОНХС-гийн хөрөнгө оруулалтын ажлын тендер шалгаруулалтыг аймгийн ОНӨГ-аас дараах байдлаар зохион байгуулсан байна. Үүнд:

- Аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр хийгдэх хөрөнгө оруулалтын шинж чанартай нийт 4 ажлын 2 ажлыг НТШ-ээр, 1 ажлыг ХА-аар, 1 ажлыг ЗҮ-ээр шалгаруулахаар батлагдсан боловч гүйцэтгэлээр 1 ажлыг нээлттэй тендер шалгаруулалтаар, 1 ажлыг ЗҮ-ээр, 2 ажилд шууд гэрээ байгуулсан байна. Энэ нь “Авто замын их засварын ажил”-ын тендерийг 2 удаа зарласан боловч тендерийн материал ирүүлээгүй, “Боловсролын байгууллагуудыг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах” ажлын тендер шалгаруулалт шаардлага хангасан гүйцэтгэгч шалгараагүй тул аймгийн ОНӨГ-аас шууд гэрээ байгуулах зөвлөмж хүргүүлсэнтэй тус тус холбоотой байна.
- Сүмбэр сумын ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын шинжтэй нийт 6 ажлаас 1 ажилд НТШ, 1 ажлыг ЗҮ, 5 ажлыг ХА-аар

төлөвлөсөн боловч гүйцэтгэлээр 1 ажлыг НТШ-аар, 1 ажлыг ЗҮ-ээр, 2 ажлыг ХА-аар, 2 ажилд шууд гэрээ байгуулсан байна. Энэ нь “6-р цэцэрлэгийн гадна хашааны ажил”-ын тендер шалгаруулалтад шаардлага хангасан гүйцэтгэгч шалгараагүйтэй тус тус холбоотой байна. “5 дугаар сургуулийн спорт заалны шалны засварын ажил”-д шалгарсан гүйцэтгэгч гэрээ байгуулахаас татгалзсан байна.

- Шивээговь сумын ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын шинжтэй нийт 3 ажлаас 1 ажилд ЗҮ, 2 ажилд ХА-аар тендер шалгаруулалтыг зохион байгуулсан байна.
- Баянтал сумын ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын шинжтэй 1 ажлыг харьцуулалт аргаар тендер шалгаруулалтыг зохион байгуулсан байна.

Аймгийн ОНӨГ-аас сонгон шалгаруулсан тендер оролцогчдоос гомдол гараагүй байна.

Аймаг, сумдын ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ажлын тендер шалгаруулалтад гүйцэтгэгч материалаа ирүүлэхгүй, шалгарсан ч гэрээ байгуулахаас татгалзсан тохиолдлууд гарч байгаа нь ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ажлын төсөв тооцооллыг бодитой хийдэггүй, ажлыг хэт жижиглэн баталсантай холбоотой байна.

Иймд ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын жагсаалтыг жижиглэн батлахгүй байх, төсөв тооцооллыг бодитой гаргаж байх шаардлагатай байна.

2.2.2 Аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр хийгдсэн хөрөнгө оруулалтын зарим ажилд захиалагчийн хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүйгээс дутуу хийгдсэн ажлыг улсын комисс хүлээн авсан байна.

Аймгийн хэмжээнд нийт 574.7 сая төгрөгийн 14 ажил өмнөх оноос шилжин ирснээс аймгийн ОНХС-гийн 552.0 сая төгрөгийн 9 ажил байгаа ба 2019 онд шинээр хэрэгжүүлэхээр 1,374.0 сая төгрөгийн 69 хөтөлбөр, төсөл арга хэмжээг баталсан байна.

2019 онд шинээр хэрэгжүүлэх ажлын жагсаалтад хөрөнгө оруулалтын шинжтэй 356.6 сая төгрөгийн 15 ажил, тоног төхөөрөмж худалдан авах 118.3 сая төгрөгийн 9 ажил, их засварын 235.7 сая төгрөгийн 4 ажил, 663.4 сая төгрөгийн 40 хөтөлбөр, төсөл арга хэмжээ байна.

2019 онд аймаг, сумдын ОНХС-гаар нийт 1,948.6 сая төгрөгийн 69 хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 1,912.7 сая төгрөгийн санхүүжилтийг авч, 43.3 сая төгрөгийн эхний үлдэгдлийг дутуу тооцоолж, нийт 235.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан байна.

Аймаг, сумдын ОНХС-гийн санхүүжилт, гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал /сая төгрөгөөр/:

Хүснэгт 8

ОНХС-гийн нэр	Гүйцэтгэлээрх санхүүжилт	Гүйцэтгэл	Зөрүү	Дутуу тодотгосон дүн	Үлдэгдэл
Аймгийн ОНХС	1,265.4	1,157.7	107.7	19.7	127.4

Сүмбэр сумын ОНХС	404.0	389.3	14.7	23.6	38.3
Шивээговь сумын ОНХС	158.4	110.8	47.6	0.0	47.6
Баянтал сумын ОНХС	85.0	62.6	22.4	-	22.4
Нийт дүн	1,912.7	1,720.3	192.4	43.3	235.7

Хүснэгтээс харахад: 2019 оны санхүүжилтээс аймгийн ОНХС-д 127.4 сая, Сүмбэр сумын ОНХС-д 38.3 сая, Шивээговь сумын ОНХС-д 47.6 сая, Баянтал сумын ОНХС-д 22.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Аудитын явцад ОНХС-гийн хөрөнгөөр хийгдсэн ажлын баримт бичгийг ажлын гүйцэтгэлтэй тулган баталгаажуулахад дараах зөрчил дутагдал илэрлээ.

Аймгийн ОНХС-ийн зарцуулалт:

а. “Цэргийн алдар” хөшөөний тохижилтын ажлын гэрээг 112.4 сая төгрөгөөр “Энх-Энэрэлийн өргөө” ХХК-тай хийж, гүйцэтгэлээр 110.9 сая төгрөгийг олгосон ба ажлыг зураг төсвийн дагуу чанартай бүрэн гүйцэтгээгүй, чанартай материалаар хийгээгүй байхад комисс хүлээн авсан.

2018 онд “Топ Универсал констракшн” ХХК-тай 10.1 сая төгрөгийн өртөгтэй усан оргилуурыг ажлыг гүйцэтгүүлэхээр нэмэлт гэрээ байгуулсан бөгөөд уг ажлыг бүрэн дуусаагүй байхад улсын комисс хүлээн авч санхүүжилтийг бүрэн олгосон байна. Гэвч 2019 онд “Энх-Энэрэлийн өргөө” компанитай байгуулсан гэрээний үнийн дүнд усан оргилуурын гэрэлтүүлэг, цахилгааны ажилд 20.0 сая төгрөгийг дахин төлөвлөж зарцуулсан боловч ажлын гүйцэтгэл тодорхойгүй, хяналт тавих эрх бүхий байгууллагуудад нарийвчилсан хяналтын дүгнэлтүүд байхгүй байна.

Дээрх ажлын хяналтын зардалд 1.8 сая төгрөгийг олгосон боловч АЗДТГ болон ГХБХБГ-ын холбогдох мэргэжилтнүүд хяналтыг хангалтгүй хэрэгжүүлж ажилласан байна.

б. Цэргийн алдар хөшөөний ажлын захиалагч төлөвлөлтийг дутуу хийснээс хавтанг шахах хашлага нэмж хийх нэрийдлээр 7.4 сая төгрөгийн нэмэлт гэрээг Энх “Энэрэлийн өргөө” ХХК-тай байгуулсан ба санхүүжилтийг бүрэн олгосон. Уг ажилд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлээгүй. Аудитын явцад нэмэлт гэрээгээр хийгдсэн ажлын бодит гүйцэтгэлтэй танилцахад нэмэлт хийгдсэн ажлыг захиалагч болон захиалагчийн хяналтыг гүйцэтгэгч байгууллага бодитоор үзүүлээгүй, ямар ажил хийсэн нь тодорхойгүй, төсвийг давхардуулан авсан гэх үндэслэлтэй байна.

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4, 16 дугаар зүйлийн 16.5.2, 24 дүгээр зүйлийн 24.4, ТБОНӨХБАҮХАТХ-ийн 41 дүгээр зүйлийн 41.1.1, 41.2, 46 дугаар зүйлийн 46.1.4 дэх заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд аймгийн ЗДТГ болон ГХБХБГ-т холбогдох хууль журмын дагуу дутуу ажлыг бүрэн гүйцээж хүлээн авах, гүйцэтгэлийг баталгаажуулах, материалын чанар хийцэд анхаарах, захиалагчийн хяналтыг сайжруулж ажиллах **албан шаардлага** хүргүүлж байна.

в. Баяр наадмын зардлыг батлахдаа журмын дагуу 10.0 сая төгрөгийг зарцуулах байтал жишиг нормыг хэтрүүлэн зардлыг 35.0 сая төгрөгөөр баталж, 25.0 сая төгрөг илүү зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4 дүгээр заалт, МУЗГ-ын 271 дүгээр тогтоолоор баталсан “Жишиг хэмжээг шинэчлэн тогтоох тухай” журмын 1 дүгээр зүйлийг тус тус зөрчсөн байна.

Иймд аймгийн ИТХ, Засаг даргад хууль тогтоомжоор батлагдсан жишиг хэмжээг хэтрүүлэн төсвийг батлахгүй байх, холбогдох хууль, журмыг мөрдөж ажиллах **зөвлөмж** хүргүүлж байна.

г. ОНХС-гаас зураг төсөв боловсруулах ажлын урьдчилгааг ажил гүйцэтгэх гэрээнд 50 хувиар санхүүжүүлэхээр тусгасан боловч гүйцэтгэлээр санхүүжилтийг 90 хувиар буюу гэрээний дүнгээс 5.5 сая төгрөгөөр илүү олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.8, 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.4, 16.5.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд санхүүгийн тайлангийн аудитаар аймгийн СТСХ-т зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн байна.

Баянтал сумын ОНХС-гийн зарцуулалт:

Баянтал сумын ОНХС нь Зорилтот бүлэгт чиглэсэн хөтөлбөрийн хөрөнгийг нийт 1.2 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна. Тухайлбал: өрхийн хөгжлийг дэмжих арга хэмжээг 0.7 сая, ахмад настнуудад чиглэсэн арга хэмжээг 0.5 сая, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг идэвхжүүлэх арга хэмжээг 0.065 сая, нийт 1.2 сая төгрөгөөр тус тус хэтрүүлж зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, 41 дүгээр зүйлийн 41.2.2 тус тус зөрсөн байна.

Иймд тус сумын Засаг даргад батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах **зөвлөмж** хүргүүлж байна.

ОНХС-гийн хөтөлбөр, төсөл арга хэмжээний зардлыг багасгаагүй сангийн зорилгодоо нийцсэн хөрөнгө оруулалтын ажлыг илүү түлхүү төлөвлөж, гүйцэтгээгүй ба тэмцээн уралдаан, сургалт, хоол, бэлэг худалдан авах зэрэг нэг удаагийн шинжтэй урсгал зардалд зарцуулсан байна.

Үүнийг хүснэгтээр харуулбал /сая.төг/:

ОНХС	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Хүснэгт №9
		Мөнгөн дүн
Аймаг	86	234.8
Сүмбэр	15	18.6
Шивээговь	35	10.2
Баянтал	2	1.5
Дүн	138	265.1

Хүснэгтээс харахад ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн нэг удаагийн шинжтэй урсгал зардлын 88.6%-ийг аймагт, 7%-ийг Сүмбэр суманд, 3.8%-ийг Шивээговь суманд, 0.6 %-ийг Баянтал суманд зарцуулсан байна.

Аймгийн хэмжээнд ОНХС-гийн хөрөнгийг хөтөлбөр нэрээр хэт жижиглэн баталж, бодит гүйцэтгэлээр уг хөтөлбөрүүдэд сумдын иргэд жигд хамрагдахгүй зөвхөн аймгийн хэмжээнд зарцуулагдаж байна.

Иргэдээс авсан санал асуулгаар “Та орон нутагтаа тус сангийн хөрөнгөөр хийгдэж буй бүтээн байгуулалтын ажлуудад хэр сэтгэл хангалуун байдаг вэ?” гэсэн асуулгад 52 нь буюу 32% нь хангалттай, 58 нь буюу 36% нь хангалтгүй, 53 нь буюу 33% нь мэдэхгүй гэж хариулсан байна.

Мөн “Таны оршин суугаа нутаг дэвсгэрт ОНХС-гаар хэрэгжсэн орон нутгийн хөгжилд нэмэр болохуйц, үр дүнтэй бүтээн байгуулалтын ажлуудаас нэрлэнэ үү” гэсэн асуулгад Сүмбэр сумын ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн дараах ажлуудыг нэрлэжээ.

Үүнд:

- Аймгийн явган хүний зам
- Таксины зогсоол
- Нийтийн орон сууцны гаднах автомашины зогсоол
- Гэрэлтүүлэг
- 5 дугаар сургуулийн спорт заалны шалны засварын ажил,
- Цэвэр усны эх үүсвэрийн хамгаалалтын дэглэмийг сайжруулах алсын хяналтын системд нэвтрүүлэх 7 км газар шилэн кабель татах ажил,
- Нийтийн эзэмшлийн орон сууцны 2-р байрны подвалын шугам сүлжээний их засвар,
- Нийтийн эзэмшлийн орон сууцны 121-127-р байрны дээврийн хэсэгчилсэн засварын ажил

Мөн Сүмбэр болон Шивээговь сумын хувьд ОНХС-гийн хөрөнгөөр хийгдсэн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний анхан шатны баримтын бүрдлийг бүрэн бүрдүүлж өмнөх оноос дэвшилттэй ажилласан байна.

ОНХС-гийн зорилго нь орон нутгийн хөгжлийг дэмжих, бүс нутгийн хөгжлийг тэнцвэртэй байлгах, ард иргэд тогтвор суурьшилтай амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэгддэг боловч нийгэм эдийн засгийн ач холбогдол бүхий урт удаан хугацаанд үр өгөөжөө өгөх хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажилд сангийн хөрөнгийг зарцуулах шаардлагатай байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.2, 24 дүгээр зүйлийн 24.4, 60 дугаар зүйлийн 60.3.3, 60.3.4, 60.3.6, Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3, 4.2.4 дэх заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Цаашид аймаг, сумдын Засаг дарга нарт хөтөлбөр, төсөл арга хэмжээний зардлыг багасгаж, сангийн зорилгодоо нийцсэн хөрөнгө оруулалтын ажлыг илүү түлхүү төлөвлөж, гүйцэтгэх *албан шаардлага* хүргүүлж байна.

2.2.3 ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтыг холбогдох байгууллагын данс бүртгэлд бүртгүүлэх шийдвэр гарсан боловч ашиглагч байгууллагад бүрэн бүртгэгдээгүй байна.

Аймгийн ИТХТ-ийн 2019.12.13-ны өдрийн 50, 2020.04.15-ны өдрийн 25 дугаар тогтоолоор аймаг, сумдын ОНХС-гийн хөрөнгөөр 2019 онд хийгдсэн хөрөнгө оруулалтын 204.8 сая төгрөгийн ажлыг орон нутгийн өмчид бүртгэх зөвшөөрөл олгосон бөгөөд уг тогтоолын дагуу хөрөнгийг данс бүртгэлд тусгасан байна.

Тайлант онд ОНХС-гийн хөрөнгөөр бий болсон хөрөнгийн тоо хэмжээ болон санхүүгийн бүртгэл тайланд тусгахгүй орхигдуулдаг зөрчил өмнөх оноос буурсан хэдий ч ашиглагч байгууллагын данс бүртгэлд хөрөнгийг бүртгүүлээгүй зөрчил байсаар байна. Тухайлбал:

Аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр хийгдсэн 4 ажлын 622.5 сая төгрөгийн ажлыг ашиглагч байгууллагуудад бүртгүүлээгүй байсныг СТА-ын явцад илрүүлж зөвлөмж өгсөн бөгөөд 2020 онд зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна.

Орон нутгийн тусгай хамгаалалтын арга хэмжээний зардлаас нийт 5.3 сая төгрөгийн бараа материал худалдан авсан боловч данс бүртгэлд тусгаагүй, орлогоор бүртгээгүй байсныг санхүүгийн тайлангийн аудитад албан шаардлага өгч зөрчлийг арилгуулсан байна.

Баянтал сумын Иргэний танхимд зориулж худалдан авсан 8.4 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг Баянтал сумын ЗДТГ-ын хөрөнгөд бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2, Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9 дүгээр зүйлийн 9.12 дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд Баянтал сумын Засаг даргад ашиглагч байгууллагад хөрөнгийг бүртгүүлэх **албан шаардлага** хүргүүлэхээр шийдвэрлэв.

ОНХС-гийн хөрөнгийн төлөвлөлт, хэрэгжилийг хууль журмын дагуу хянаж тайлагнасан уу

Бүлэг 3

ОНХС-гийн хөрөнгийн төлөвлөлт, хэрэгжилтэд холбогдох байгууллага, иргэдээс тавих хяналт хангалтгүй байна.

3.1. ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлд хяналт шинжилгээ үнэлгээ хийгээгүй байна.

3.1.1 Баянтал сумын ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөтөлбөр, төсөл арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлийн явцад хяналт тавьж ажиллаагүй байна.

Сангийн сайдын 2018 оны 9 дүгээр сарын 228 дугаар тушаалаар “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9 дүгээр зүйлийн 9.4, Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт тайлагналын журам”-ын 5 дугаар зүйлд заасныг баримтлан аймгийн СХАА, ИТХ-ын дэргэдэх иргэний нийгмийн байгууллага хяналт тавьж үнэлгээ хийхээр журамлагдсан.

Аудитаар ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагнал, бүртгэлд захиалагчаас болон тухайн орон нутгийн ИТХ-ын дэргэдэх Хяналтын хороо байгуулж хяналт тавьсан эсэхийг үзэхэд Сүмбэр болон Шивээговь суманд иргэдийн хяналтын хороо байгуулагдаж тайлант онд хэрэгжсэн ажлуудад хяналт тавьж ажилласан байна. Хяналт шалгалтаар зөрчил илрүүлээгүй байна.

Мөн 2019 онд “Хөгжлийн түншлэл” ТББ-аас Сүмбэр сумын 2019 оны ОНХС-гийн хөрөнгөөр хийгдсэн 8 ажилд хяналт хийж, хөрөнгийн ашиглалт хамгаалалтад анхаарах зөвлөмж хүргүүлж ажилласан байна. Уг зөвлөмжийн хэрэгжилтийг Сүмбэр сумын Засаг даргын 2019 оны А/739 тоотоор хүргүүлж ажиллажээ.

Харин Баянтал сумын ИТХ-ын дэргэдэх хяналтын хороо байгуулагдаагүй ба иргэдийн нийгмийн байгууллагаас тус сумын ОНХС-д хяналт тавьж ажиллаагүй байна.

Энэ нь Сангийн сайдын 2018 оны 9 дүгээр сарын 228 дугаар тушаалаар “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9 дүгээр зүйлийн 9.4 дэх заалтыг зөрчсөн байна.

Иймд Баянтал сумын ИТХ-д тус хурлын дэргэдэх Хяналтын хороог сайн дурын идэвхтэн иргэдтэй хамтран байгуулж, ОНХС-гаас хэрэгжсэн хөтөлбөр, төсөл, арга хэмжээнд хяналт тавьж ажиллах **зөвлөмж** хүргүүлж байна.

Иргэдээс авсан санал асуулгаар “Та орон нутагтаа тус сангийн хөрөнгөөр хийгдэж буй бүтээн байгуулалтын ажлууд бодитой хэрэгжиж байгаа эсэхэд хяналт тавьдаг уу?” гэсэн асуулгад 51 иргэн буюу 31% нь тийм, 112 иргэн буюу 69% нь үгүй гэж хариулжээ.

Мөн “Танд энэ сангийн үйл ажиллагаатай холбоотой санал байна уу?” гэсэн санал асуулгад ОНХС-гийн хөрөнгийн талаарх мэдээллийг иргэдэд ил тод ойлгомжтойгоор мэдээлэх, иргэний хяналтыг сайжруулах, томоохон бүтээн байгуулалтыг ажлыг хийх шаардлагатай гэж хариулсан байна.

3.1.2 Аймаг, сумын захиргааны байгууллага ОНХС-гийн хэрэгжилт, үр дүнд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийгээгүй байна.

Сангийн сайдын 2018 оны 9 дүгээр сарын 228 дугаар тушаалаар “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9 дүгээр зүйлийн 9.5-д аймгийн захиргааны байгууллагууд ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэлийн явц, үр дүнд хийх хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхээр зохицуулагдсан байна.

Аймгийн ЗДТГ-ын ХШҮДАХ болон СХАА-аас 2019 онд аймаг, сумдын ОНХС-гийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийгдээгүй байна.

Мөн аймгийн ЗДТГ болон ГХБХБГ-аас хяналт шалгалтыг хангалтгүй гүйцэтгэсэн байна.

Аймгийн СХАА нь аймаг, сумдын ОНХС-д хяналт шалгалт хийхээр төлөвлөсөн боловч хяналт шалгалтыг хийх хугацаа болоогүй байна.

3.2 ОНХС-гийн тайлан, үр дүнг АИТХ-аар хэлэлцээгүй байна.

3.2.1 ОНХС-гийн тайланг холбогдох байгууллагад хүргүүлж ажилласан боловч үр дүнг хэлэлцээгүй байна.

Аймаг, сумын ОНХС болон хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтнүүд ОНХС-гийн хөрөнгөөр хийгдсэн ажлын гүйцэтгэлийн тайланг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст дараа оны 2 дугаар сарын 01-ний өдрийн дотор жилдээ 1 удаа, Орон нутгийн өмчийн газар, "Тогтвортой амьжиргаа-3" төсөлд Сангийн сайдын 228 дугаар журмын дагуу тогтоосон хугацаанд тайлагнан ажилласан байна.

Сумдын санхүүгийн алба ОНХС-ийн төсвийн гүйцэтгэлийн тайланг СТСХ-т сар бүр тайлагнасан байна.

Мөн Сүмбэр сумын ОНХС нь аймгийн "Давхар дэлгэц", Говьсүмбэрийн телевизээр 2019 оны ОНХС-гийн тайланг 4 удаагийн давталттайгаар нэвтрүүлсэн байна.

2019 онд ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ажлын хэвлэмэл тайланг Аймаг сумдын худалдааны төвүүд болон ус түгээх байрнуудын мэдээллийн самбарт тайлангийн хэвлэмэл хуудсыг байршуулж, иргэдэд гарын авлага маягаар тараасан байна.

2019 онд Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжүүлэн хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний талаар мэдээллийн сан бүрдүүлж, төслийн санхүүжилтийг хянах, тайлагнахад Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах үүрэг бүхий удирдлага, төрийн албан хаагчдыг нэгдсэн мэдээллээр хангах удирдлагын мэдээллийн системийг ашиглаж эхэлсэн байна. Уг мэдээллийн системд сумдын ОНХС-гийн мэргэжилтнүүд болон, багийн Засаг дарга нар ОНХС-гийн мэдээллийг байршуулсан байна.

Мөн "Тогтвортой амьжиргаа-3" төсөл нь ОНХС-гийн www.tusuv-oronnutag.mof.gov.mn албан ёсны цахим хуудсыг ашиглалтад оруулсан байна.

Гэвч аймгийн ХОХБТХ нь аймгийн болон сумдын ОНХС-гийн хэрэгжилтийн жилийн эцсийн тайланг нэгтгэж, Сангийн яаманд хүргүүлдэг боловч Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар баталсан "ОНХС-гийн үйл ажиллагааны журам"-ын 9 дүгээр зүйлийн 9.7-д "Энэ журмын 9.3-т заасан дүгнэлт, Засаг даргын шийдвэрийг тухайн шатны ИТХ-аар жил бүр, төсвийн гүйцэтгэлийн болон санхүүгийн тайлангийн талаарх Засаг даргын мэдээллийн хамт хэлэлцүүлнэ", 9.8-д "Энэ журмын 9.4, 9.5-д заасан байгууллага дангаараа болон иргэд, иргэний нийгмийн байгууллагын төлөөллийг оролцуулан ОНХС-гийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалт, аудит, хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан, дүгнэлт, зөвлөмж, акт, албан шаардлагыг тухайн шатны ИТХ-аар жил бүр хэлэлцүүлнэ" гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллахгүй байна.

Иймд аймаг, сумдын ИТХ, Засаг дарга нарт холбогдох журмыг мөрдөж ажиллах **зөвлөмж** өгөхөөр шийдвэрлэв.

3.2.2 Өмнөх аудитаар өгөгдсөн албан шаардлагыг хэрэгжүүлж, зөвлөмжөөр өгөгдсөн зөрчлийг давтан гаргасан байна.

Өмнөх оны нийцлийн аудитаар нийт 603.7 сая төгрөгийн зөрчил дутагдал илэрснээс 230.9 сая төгрөгийн албан шаардлага, 372.8 сая төгрөгийн алдаа, зөрчлийг арилгуулах зөвлөмж өгөгдсөн байна. Үүнээс албан шаардлагыг 100.0%, зөвлөмжийг 87.0%-тай хэрэгжүүлж ажилласан байна.

Аймаг, сумдын ОНХС нь өмнөх аудитаар өгөгдсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна. Тухайлбал:

Аймгийн ОНХС:

- ОНХС-гийн хөрөнгөөр хийгдсэн зарим ажлууд чанарын шаардлага хангаагүй, үр дүн, ашиглалт муутай байгаад анхаарч ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх
- Ажлын санхүүжилтийг гэрээнд заасан хуваарийн дагуу олгож байх
- ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжих хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээнд дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэх

Баянтал сумын ОНХС:

- ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжих хөтөлбөр төсөл арга хэмжээнд явцын хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэх

Алдаа зөрчил давтан гаргаж, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй холбогдох албан тушаалтнуудад албан шаардлага хүргүүлээ.


3.2.3 Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн төлөвлөлтийг бодитой хийгээгүйгээс тус сангийн үйл ажиллагаа нь орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоо бүрэн хангаагүй байна.

ОНХС-гийн тодорхой хувийг төсөл хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулна гэсэн хуулийн нарийн зохицуулалт, заалт байхгүйгээс хөрөнгийг хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нэрээр жижиглэн нэг удаагийн урсгал зардлын шинж чанартай арга хэмжээнд зарцуулсан нь орон нутгийн хөгжлийг дэмжих, бүс нутгийн тогтвортой хөгжлийг хангах, ард иргэдийн тогтвор суурьшилтай амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлэх зорилтыг бүрэн хангаж чадахгүй байна.

ОНХС-гийн хөрөнгийг тухайн орон нутагт урт удаан хугацаанд үр ашгаа өгөх, бүтээн байгуулалтын ажилд зарцуулах нь зүйтэй байна.

Тайлант онд гүйцэтгээгүй ажил болон гэрээний хэмнэлтээс үүссэн сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 2015-2019 оны байдлаар дараах байдалтай байжээ. Үүнийг дүрслэлээр харуулбал:

Дүрслэл №2



Дүрслэлээс харахад тухайн онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөлтийг бодитой, үндэслэлтэй хийгээгүйгээс сангийн чөлөөт мөнгөн хөрөнгийн үлдэгдэл жил бүр байсаар байна.

Мөн жил бүрийн аудитаар илэрсэн зөрчлөөс харахад сангийн хөрөнгийн төлөвлөлтийн процесс хангалтгүй байгаа нь харагдаж байна. Иймээс төлөвлөлтийг хэрэгжүүлэх процессыг сайжруулах талаар холбогдох хууль журамд нарийн зохицуулалтыг хийх шаардлагатай гэж үзлээ.

Аудитаар нийт 510.4 сая төгрөгийн зөрчил дутагдал илрүүлснээс 311.0 сая төгрөгийн 6 албан шаардлага, 199.4 сая төгрөгийн алдаа, зөрчлийг арилгуулах 15 зөвлөмж өглөө.

ДУГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна.

1. ОНХНС-гийн эх үүсвэрийг хууль журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлсэн боловч нийт 10.9 сая төгрөгийн дутуу санхүүжилт олгогдсон бол ОН-ийн төсвөөс санхүүжих орлогыг 25.0 сая төгрөгөөр дутуу хуваарилсан байна.
2. Зураг төсөв батлагдаагүй төсөл, арга хэмжээг ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөж, батлуулсан, мөн аймаг, сумдын ОНХС-гийн эх үүсвэрийн эхний үлдэгдлийг 43.1 сая төгрөгөөр дутуу тооцоолсон байна.
3. ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх нийт ажлын 48.0%-ийг хөтөлбөр төсөл арга хэмжээний зардал эзэлж байна.
4. ОНХС-гийн хөрөнгөөр сум, орон нутагт бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулсан байна.
5. Аймгийн ОНХС-гаар хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын зарим ажилд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлээгүй, дутуу ажлыг улсын комисс хүлээн авсан байна.
6. ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтыг холбогдох байгууллагын данс бүртгэлд бүртгүүлэх шийдвэр гарсан боловч ашиглагч байгууллагад бүрэн бүртгэгдээгүй байна.
7. ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлд хяналт шинжилгээ үнэлгээ хийгээгүй байна.
8. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн төлөвлөлтийг бодитой хийгээгүйгээс тус сангийн үйл ажиллагаа нь орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоо бүрэн хангаагүй байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүнд үндэслэн дор дурдсан албан тушаалтанд дараах зөвлөмжийг өгч байна.

Аймаг, сүмдын Иргэдийн төлөөлөгчдийн хуралд:

1. ОНХС-гийн хөрөнгийг нийгэм, эдийн засгийн ач холбогдол бүхий урт удаан хугацаанд үр өгөөжөө өгөх хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажилд төлөвлөгдсөн эсэхийг хянаж батлах
2. Хөтөлбөр, төсөл арга хэмжээний зардлыг багасгаж, сангийн зорилгодоо нийцсэн хөрөнгө оруулалтын ажлыг илүү түлхүү төлөвлөж батлах, нэг удаагийн шинжтэй урсгал зардлыг батлахгүй байх, хөтөлбөр арга хэмжээний зардлын задаргааг нарийвчлан гаргуулах
3. Хөтөлбөр, арга хэмжээний зардлыг үндэслэлгүйгээр нэмж тодотгохгүй байх, холбогдох хууль журамд нийцүүлэн шийдвэр гаргаж байх
4. ИТХ-ын дэргэдэх Хяналтын хороог сайн дурын идэвхтэн иргэдтэй хамтран байгуулж, ОНХС-гаас хэрэгжсэн хөтөлбөр, төсөл, арга хэмжээнд хяналт тавьж ажиллах
5. Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар баталсан “ОНХС-гийн үйл ажиллагааны журам”-ын 9 дүгээр зүйлийн 9.7, 9.8 дахь заалтуудыг хэрэгжүүлж ажиллах

Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн даргад:

1. ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ажлын захиалагчийн хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлж ажиллах, гүйцэтгэгчээр ажлыг чанартай хийлгэж бүрэн дуусаагүй ажлыг хүлээн авахгүй байх
2. Хөтөлбөр, төсөл арга хэмжээний зардлыг багасгаж сангийн зорилгодоо нийцсэн хөрөнгө оруулалтын ажлыг илүү түлхүү төлөвлөж, хэрэгжүүлэх, нэг удаагийн шинжтэй урсгал зардлыг төлөвлөхгүй байх, хөтөлбөр арга хэмжээний зардлын задаргааг нарийвчлан гаргаж батлуулах
3. Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар баталсан “ОНХС-гийн үйл ажиллагааны журам”-ын 9 дүгээр зүйлийн 9.7, 9.8 дахь заалтуудыг хэрэгжүүлж ажиллах

Аймгийн Санхүү төрийн сангийн хэлтэст:

1. ОНХС-гийн эхний үлдэгдлийг үнэн зөв тооцож төлөвлөж байх
2. Орон нутгийн орлогоос ОНХС-д олгох эх үүсвэрийг хуваарийн дагуу санхүүжүүлж байх

Сүмдын Засаг дарга нарт

1. ОНХС-гийн эхний үлдэгдлийг үнэн зөв тооцож төлөвлөж байх
2. ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө холбогдох хууль тогтоомж, зааврыг баримтлан олон нийтийн оролцоог

- нэмэгдүүлэх, иргэдийн саналыг үнэн бодитой байдлаар тусгаж, зураг төсөвгүй арга хэмжээг төлөвлөхгүй байх
3. ОНХС-гийн санхүүжилтээр бий болсон хөрөнгийг холбогдох байгууллагын данс бүртгэлд бүрэн тусгуулах, хөрөнгийг орхигдуулахгүй байх, хянах
 4. Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар баталсан “ОНХС-гийн үйл ажиллагааны журам”-ын 9 дүгээр зүйлийн 9.7, 9.8 дахь заалтуудыг хэрэгжүүлж ажиллах
 5. ИТХ-ын дэргэдэх Хяналтын хороог сайн дурын идэвхтэн иргэдтэй хамтран байгуулж, ОНХС-гаас хэрэгжсэн хөтөлбөр, төсөл, арга хэмжээнд хяналт тавьж ажиллах,

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ

Аймгийн ХОХБТХ болон сумдын Засаг дарга нараас ирүүлсэн санал:



**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг,
Найрамдал хотхон, Утас/Факс: (976) 7054 3118,
И-мэйл: zdtg.gsa@gmail.com, Вэбсайт: www.govisumber.gov.mn

2020. 11. 13 № 01/1239

танай _____-ны № _____-т

**АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗАРТ**

Говьсүмбэр аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн 2019 оны үйл ажиллагааны үр дүнд хийсэн нийцлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцаад саналыг хавсралтаар хүргүүлэв.

Хавсралт 5 хуудастай.

ДАРГА  Д.СОДНОМ

М. Ундармаа
Саналын тайланг
тусгана, тайлбарыг
хувиар, тайланг оруулж
барагдсаныг мэдэгдэж
байгааг үндэслэн
428-00081 2/3



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
СҮМБЭР СУМЫН ЗАСАГ ДАРГА

42017 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, Чойр,
Утас: 7054 3249, И-мэйл: gsasumber@gmail.com

2020. 11. 14 № А/631

танай _____-ны № _____-т

ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Тус сумын 2019 оны Орон нутгийн хөгжлийн санд хийгдсэн нийцлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа, тайлангийн төсөлд өгөх саналгүй болно.

ДАРГА



Т.БАТ-ӨРДЭНЭ

Ц.Батсайхан
Санхүүг тайлалд
туулан, танилцаж
зөвлөх баталгаажуулах
Өмнөд 11.14



ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГА

42030 Говьсүмбэр аймаг, Шивээговь сум,
Утас: 7054 6426, И-мэйл: shiveegovi.zdtg@gmail.com

2020.11.13 № 1/333
танай _____-ны № _____-т

Тайлбар хүргүүлэх тухай

М. Ундершарв
Сансарт Тайланг
Тусламж, нутаг
Баталгаа хүргүүлэх

2020.11.13

Шивээговь сумын ОНХС-гийн 2019 оны үйл ажиллагааны үр дүнд хийсэн нийцлийн аудитаар илэрсэн төлбөр, зөрчлийн нэгтгэлтэй танилцаж дараах тайлбарыг хүргүүлж байна. Үүнд:

1. **Зөрчил:** Шивээговь суманд ЗДТГ-ын 2019 оны "Орон нутгийн хөгжлийн сан"-ийн хөрөнгө оруулалтаар хийгдэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний ажлын саналын жагсаалтад ороогүй, зураг төсөв батлагдаагүй "Төв талбайг тохижуулах, усан оргилуур байгуулах" 50.0 сая төгрөгийн ажлыг Шивээговь сумын ИТХ-аар баталсан.

Тайлбар: Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай 18 дугаар зүйлийн 18.1.2 /б/, 12 дугаар зүйлийн 12.1.3 дахь заалтын дагуу сумын 2019 оны оны "Орон нутгийн хөгжлийн сан"-ийн хөрөнгө оруулалтаар хийгдэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний ажлын саналын жагсаалтад сумын Иргэдийн хурлын төлөөлөгч санал гаргаж, сумын төв талбайг тохижуулах, усан оргилуур байгуулах ажлыг хэлэлцэн баталсан. Иймд Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай 29 дүгээр зүйлийн 29.1.1 /а/ дахь заалтын дагуу сумын Засаг дарга нь тогтоолын хэрэгжилтийг хангаж ажилласан болно.

2. **Зөрчил:** ОНХС-ын хөтөлбөр, төсөл арга хэмжээний зардлыг багасгаагүй сангийн зорилгодоо нийцсэн хөрөнгө оруулалтын ажлыг илүү түлхүү төлөвлөж, гүйцэтгээгүй ба тэмцээн уралдаан, сургалт, хоол, бэлэг худалдан авах нэг удаагийн шинжтэй зардалд зарцуулсан байна.

Тайлбар: Суманд хэрэгжүүлдэг дэд хөтөлбөрийг Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.4.1 дэх заалтын хүрээнд хэрэгжүүлдэг бөгөөд нийгмийн салбарын холбогдох хуулиудын хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулан ажиллаж байна. /Жишээ нь: Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.1, 19.1.4, Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн

4242 0109

14.5.2, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.1, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2 дахь заалт гэх мэт./

Дэд хөтөлбөрийн зардлыг тэмцээн уралдаан, сургалт, хоол зэрэг нэг удаагийн шинжтэй зардалд зарцуулахыг хориглосон тухай тодорхой шийдвэр байхгүй, мөн аймгийн холбогдох хэлтэс, албанаас дэд хөтөлбөрийн зардлыг зарцуулах чиглэлийг тодорхой болгож үүрэг чиглэл өгч байсан удаагүй тул 2019 онд дээрх зардалд зарцуулсан болно. Гэвч бид 2019 онд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн өрөөг тохижуулах зэрэг хөрөнгийн шинжтэй ажлуудыг санаачлан хийж гүйцэтгэсэн. Мөн 2020 оноос дэд хөтөлбөрийн зардлыг хөрөнгийн шинжтэй ажилд зарцуулах бодлогыг барин ажиллаж байгааг та бүхэн харгалзан үзнэ үү.

Иймд тус албан шаардлагыг хүлээн зөвшөөрөхгүй байгаа тул дээрх байдлыг дахин нягталж, харгалзан үзнэ үү.



С.ЯГААНЦЭЦЭГ



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГА

42040 Говьсүмбэр аймаг, Баянтал сум, Лүн.
Утас: 9411 3190, <http://www.bayantal.gs.gov.mn>

2020.11.14 № 386


танай _____-ны № _____-т

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ

Баянтал сумын ОНХС-гийн 2019 оны үйл ажиллагааны
үр дүнд хийсэн нийцлийн аудитаар илэрсэн төлбөр, зөрчлийн
нэгтгэлийн төсөлтэй танилцав. Илэрсэн зөрчлүүдийг арилгах
хугацааг 2021 оны эхний хагас жилд албан шаардлагын хариуг
хүргүүлэхээр хүсэлт гаргаж байна.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ  Ш.ШИНЭБАЯР




Н.Ундаржав
Баталгаангуулах


11/14

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛД ХИЙСЭН ТАЙЛБАР

Холбогдох байгууллагуудаас ирүүлсэн тайлангийн төсөлд өгсөн саналтай танилцаад хууль эрхийн үндэслэлтэй тайлбар ирүүлээгүй тул тайланд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзлээ.



ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2020 оны 11 сарын 17 өдөр

Дугаар А/32

Чойр

Нийцлийн аудитын тайланг
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 10 дугаар зүйл, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2016 оны А/146 дугаар тушаалаар батлагдсан "Нийцлийн аудитын түр журам"-ын 9 дүгээр зүйлийн 9.2, А/95 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 7.1, 2018 оны А/207 дугаар тушаалын 5 дугаар хавсралтын 1.1, 1.3, 2.4 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2019 оны 05 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/53 дугаар тушаал, Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд Үндэсний аудитын газрын нэгдсэн удирдамжаар "Орон нутгийн хөгжлийн сангийн 2019 оны зарцуулалт, үр дүн"-д хийгдсэн Нийцлийн аудитын тайлан, илэрсэн зөрчлийн жагсаалт, албан шаардлагыг хавсралтаар баталсугай.

2. "Орон нутгийн хөгжлийн сангийн 2019 оны зарцуулалт, үр дүн"-д хийгдсэн Нийцлийн аудитын тайланг Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газар, аймаг, сумдын ИТХ болон Засаг дарга нарт тус тус хүргүүлсүгэй.

3. Аудитын тайланд дурдагдсан зөрчлүүдийг арилган, өгөгдсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, түүний үр дүнг 2021 оны 09 дүгээр сарын 20-ны дотор Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймаг, сумдын ИТХ-ын болон Засаг дарга нарт тус тус зөвлөсүгэй.

4. Аудитын тайланд тусгагдсан зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг ахлах аудитор Ц.Батсайхан, М.Ундармаа нарт даалгасугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.САРАНТУЯА

D:\DOTOOD AJIL\TUSHAAL.doc

008010093



**ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг
Утас/Факс: 976-7054 3179
И-мэйл: govsumber@audit.gov.mn

2020.11.17 № 322

танай _____-ны № _____-т

**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН
НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗАРТ**

УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2019 оны 05 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/53 дугаар тушаал, Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд Үндэсний аудитын газрын нэгдсэн удирдамжаар "Орон нутгийн хөгжлийн сангийн 2019 оны хөрөнгийн зарцуулалт, үр дүн"-д хийгдсэн Нийцлийн аудитын тайланг, судалгааны хамт хүргүүлж байна.

Хавсралт 15 хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.САРАНТУЯА



008030483